



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/42

Хэрлэн сум

Цэцэрлэг, сургуулийн завсрын  
үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4, 50.5 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих Батширээт сумын цэцэрлэгийн засвар, Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгоны сургуулийн барилгын цонх хаалга солих, дотор заслын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичиг:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	М.Хишигбаяр	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга
	Х.Гонгор	Иргэний төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ